



АХМАД НАСТНЫ СОЦИАЛЬ АСУУДАЛ: ҮР ДАГАВАР, ТӨЛӨВ ХАНДЛАГА

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн, Монголын ахмадын холбоо (МАХХ) хамтран 2019-2022 онд хэрэгжүүлсэн “Ахмад настны социаль асуудал: үр дагавар, төлөв хандлага” сэдэвт суурь судалгааны төслийн үр дүнгээр энэхүү бүтээлийг бичиж хэвлүүлэв. Уг төслийг ШУА, МАХХ-оос дэвшүүлсэн саналын үндсэн дээр тус академийн Философийн хүрээлэнгийн Социологийн салбарын судлаачид МАХХ-ны оролцоотойгоор, БШУЯ, ШУТС-ийн санхүүжилтээр гүйцэтгэсэн болно.

Энэхүү бүтээлд Монголын ахмад настнуудын социаль асуудлыг цогцоор нь авч үзэж, өнөөгийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлов.

Бүтээлийн товч агуулга. Ахмад настны социаль асуудал: судалгааны арга зүй, аргачлал ба ерөнхий дүр зураг; амьжиргааны төлөв байдал; эрүүл мэнд, сэтгэл зүйн байдал; хөдөлмөр эрхлэлт; нийгмийн оролцоо; гэр бүлийн анхаарал халамж; нийгмийн шилжилт ба дасан зохицол; ахмад настанд хандах хандлага ба ялгаварлан гадуурхалт; тэдний нийгэмд эзлэх байр суурь, цаашдын хандлага; ахмад настны асуудалд шинжлэх ухаанчаар хандах шаардлага, арга зам; зөвлөмж гэсэн дэд сэдвийг агуулна.